



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГАА-2022/09/-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор:	Х.Түвшинбаяр
	Утас: 70483413 Цахим хаяг:	tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	Д.Эрдэнэчимэг
	Утас: 70484055 Цахим хаяг:	erdenechimegd@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Ж.Бүжинханд
	Утас: 99177546 Цахим хаяг:	Bujinkhandj@audit.gov.mn
	Аудитор:	Н.Гэрэлмаа
	Утас: 99782918 Цахим хаяг:	gerleen1111@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	5
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/	8
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	11
3.5.1 Орлогын данс	12
3.5.2 Зардлын данс	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	14
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлсэн сан



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.03.25 № 177
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020493

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	749,872.3	782,584.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	209,570.0	247,300.6
33	АВЛАГА	202,294.1	192,623.8
35	БАРАА МАТЕРИАЛ	316,198.0	331,050.0
36	НӨӨЦИЙН БАРАА	4,810.2	11,610.2
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	17,000.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,365,742.5	4,410,414.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,365,742.5	4,410,414.9
39200	Биет хөрөнгө	4,303,674.3	4,311,230.3
39300	Биет бус хөрөнгө	62,068.2	99,184.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,115,614.8	5,192,999.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,857.2	36,121.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,857.2	36,121.6
41300	Өглөг	22,857.2	36,121.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,092,757.6	5,156,877.9
51	Засгийн газрын хувь оролцоо	5,092,757.6	5,156,877.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,501,915.4	1,502,351.4
51200	Хуримтлагдсан үр дүн	2,108,027.5	2,198,922.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,482,814.7	1,455,604.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,115,614.8	5,192,999.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,215,763.0	2,362,626.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	56,882.6	41,062.1
110	Орлогын албан татвар	36,151.8	25,659.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	36,151.8	25,659.7
113	Хөрөнгийн албан татвар	1,740.0	1,650.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	18,990.8	13,752.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	305,134.0	422,523.2
120	Нийтлэг татварын бус орлого	305,134.0	422,523.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,853,746.4	1,899,041.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,986,738.1	2,151,629.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,986,738.1	2,151,629.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,935,518.2	2,098,797.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,022,044.9	1,028,706.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,998.4	135,998.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	300,343.8	334,749.0
2104	Хангамж, бараа материалын зардал	53,945.8	53,407.4
2105	Нормативт зардал	31,742.5	148,905.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,099.5	24,015.5
2107	Томилолт, зочны зардал	3,893.2	2,530.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,799.6	5,669.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	353,650.5	364,815.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,051,219.9	52,832.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	229,024.9	210,996.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	74,972.1	147,312.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	154,052.7	63,684.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,003,441.5	2,065,003.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	56,882.6	41,062.1
110	Орлогын албан татвар	36,151.8	25,659.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	36,151.8	25,659.7
113	Хөрөнгийн албан татвар	1,740.0	1,650.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	18,990.8	13,752.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,098.2	4,016.2
1181	Газрын төлбөр	14,714.5	9,694.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	178.1	41.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	81,930.8	127,440.8
120	Нийтлэг татварын бус орлого	81,930.8	127,440.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,864,628.1	1,896,501.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,672,039.2	1,751,976.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,672,039.2	1,751,976.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,609,937.6	1,695,643.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,022,044.9	1,028,706.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,998.4	136,106.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	299,573.8	334,749.0
2104	Хангамж, бараа материалын зардал	49,649.0	52,388.0
2105	Нормативт зардал	28,314.6	80,730.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,999.4	25,589.0
2107	Томилолт, зочны зардал	3,893.2	2,530.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,928.8	6,581.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,535.6	28,262.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,062,101.6	56,332.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	331,402.2	313,027.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	159,604.2	188,361.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	159,604.2	188,361.2
2200	Дотоод эх үүсвэрээр	159,604.2	188,361.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-159,604.2	-188,361.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-54,000.0	-86,935.6
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	54,000.0	86,935.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	117,798.0	37,730.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	91,772.0	209,570.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	209,570.0	247,300.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөг/


Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,906,346.0	4,906,346.0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7,092.0	-7,092.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,899,254.1	4,899,254.1
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	39,450.8	39,450.8
9	Тайлант үеийн үр дүн	154,052.7	154,052.7
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,092,757.6	5,092,757.6

Говь-Алтай аймгийн Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,092,757.6	5,092,757.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	27,210.5	27,210.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,119,968.2	5,119,968.2
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-27,210.5	-27,210.5
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	436.0	436.0
19	Тайлант үеийн үр дүн	63,684.3	63,684.3
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,156,877.9	5,156,877.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,948,637.30	1,851,633.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,713,858.60	1,655,680.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,700,914.20	1,643,790.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,046,403.20	1,021,626.25
210101	Үндсэн цалин	885,720.70	802,188.73
210102	Нэмэгдэл	82,422.80	147,382.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,200.00	3,419.00
210104	Урамшуулал	57,770.10	55,527.56
210105	Гэрээт ажлын хөлс	13,289.60	13,108.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,333.00	134,580.53
210201	Тэтгэврийн даатгал	98,874.40	94,902.90
210202	Тэтгэмжийн даатгал	10,115.30	10,190.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,092.00	8,113.29
210204	Ажилгүйдлийн даатгал	2,023.50	1,939.34
210205	Эрүүл мэндийн даатгал	20,227.80	19,434.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	337,679.10	334,608.22
210301	Гэрэл, цахилгаан	11,400.00	8,990.08
210302	Түлш, халаалт	325,561.50	325,559.64
210303	Цэвэр, бохир ус	717.60	58.50
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,844.70	48,586.50
210401	Бичиг хэрэг	6,069.00	5,589.60
210402	Тээвэр, шатахуун	31,001.70	30,223.73
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,134.50	3,938.47
210404	Ном, хэвлэл	310.00	189.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,492.00	456.40
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,837.50	8,189.20
2105	Нормативт зардал	50,063.50	45,666.77
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,105.50	22,990.37
210502	Хоол, хүнс	23,808.00	20,631.41
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,150.00	2,045.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,839.70	26,559.69
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,854.90	3,598.90
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	22,984.80	22,960.79
2107	Томилолт, зочны зардал	2,729.90	1,407.80
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,729.90	1,407.80
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,017.20	4,536.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,653.50	1,471.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648.00	648.00




Говь-Алтай аймгийн Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	180.00	180.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170.10	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110.00	11.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	822.00	812.00
210807	Газрын төлбөр	133.60	82.51
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500.00	200.19
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,800.00	1,131.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,003.90	26,219.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,448.60	24,819.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,555.30	1,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,944.40	11,889.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,944.40	11,889.40
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,144.40	6,131.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,800.00	5,758.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	147,843.10	109,017.31
223001	Бусад хөрөнгө	147,843.10	109,017.31
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	86,935.60	86,935.60
230001	Эргэж төлөгдөх зээл	86,935.60	86,935.60
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,948,637.30	1,911,706.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	928,362.60	910,549.18
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	928,362.60	910,549.18
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	890,175.90	875,453.59
320001	Орон нутгийн төсвөөс	756,925.50	742,203.19
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	133,250.40	133,250.40
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,145.00	5,192.41
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	0.00	0.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,145.00	5,192.41
34	ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00
340001	Хүний хөгжил сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	113,953.80	120,510.82
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,350.90	117,771.82
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86,200.00	2,739.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	23,402.90	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	41,631.86
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	101,704.68

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	156,226.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	156,226.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,596.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,080.02
210101	Үндсэн цалин	444.06
210102	Нэмэгдэл	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00
210104	Урамшуулал	6,635.96
210105	Гэрээт ажлын хөлс	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,525.78
210201	Тэтгэврийн даатгал	1,525.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140.80



Говь-Алтай аймгийн Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210301	Гэрэл, цахилгаан	10.80
210302	Түлш, халаалт	0.00
210303	Цэвэр, бохир ус	130.00
210304	Байрны түрээс	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,861.55
210401	Бичиг хэрэг	745.36
210402	Тээвэр, шатахуун	1,851.19
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5.00
210404	Ном, хэвлэл	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	757.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	502.50
2105	Нормативт зардал	35,064.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,566.05
210502	Хоол, хүнс	1,998.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,038.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,404.00
210604	Урсгал засвар	634.20
2107	Томилолт, зочны зардал	1,123.06
210701	Гадаад албан томилолт	0.00
210702	Дотоод албан томилолт	1,123.06
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,045.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	875.20
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	670.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,718.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,118.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,630.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,130.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,130.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,500.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	3,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	159,311.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,311.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104,997.30
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,754.20
131106	Хаагдсан данс	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	48,560.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	3,084.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,084.75



3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд түүвэрт хамрагдсан Иргэдийн төлөөлөгчдийн хуралд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Гэрэлмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/86 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайшир сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төрийн хууль тогтоомжийг дээдлэн сахиж, санаачилгатай чадварлаг мэргэшсэн, ажлын албыг бүрдүүлж, нутаг дэвсгэрийн нийгэм эдийн засгийн хөгжлийн үр дүнд чиглэсэн нээлттэй, иргэдэд ойр, уян хатан, төрийн үйлчилгээг үзүүлнэ гэсэн эрхэм зорилготой.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг 2020 онд баталсан. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн чиг үүргийн байгууллагаас бусад байгууллагад даалгасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоожээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2021 онд Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,799.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 36.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 28.8 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 2,151.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 43.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 34.4 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.


3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.5 хувиар буюу 77.4 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 247.3 сая төгрөг болж 37.7 сая төгрөгөөр өссөн нь СХС-ийн зээлийн авлагыг барагдуулсан, ОНХС-ийн төлөвлөсөн ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Авлага дансны эхний үлдэгдэл 202.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 192.6 сая төгрөг болж буурсан. Тайлант хугацаанд сум хөгжүүлэх сангийн 9.7 сая төгрөгийн авлага барагдуулсантай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 342.7 сая төгрөг болж 21.7 сая төгрөгөөр өссөн нь бараа материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 159.2 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 125.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 257.4 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 342.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.



Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,064.4 сая төгрөг болж 198.0 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 79.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 293.2 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 130.3 сая төгрөгийн хөрөнгийг акталсан ба тайлант оны эцэст 6,064.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл 36.1 сая төгрөг болж 13.2 сая төгрөгөөр өссөн нь сум хөгжүүлэх санд өглөг үүссэнтэй холбоотой. Тайлант оны эцэст 36.1 сая төгрөгийн өглөгтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,156.9 сая төгрөг болж 64.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 2.5 хувиар буюу 81.5 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 2,198.9 сая төгрөг болсон байна.

3.5.1 Орлогын данс

Тайлант онд 41.1 сая төгрөгийн татварын орлого, 422.5 сая төгрөгийн татварын бус орлого, 1,899.0 сая төгрөгийн тусламж санхүүжилтийн орлого нийт 2,362.6 төгрөгийн үйл ажиллагааны орлого хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

3.5.2 Зардлын данс

Тайлант онд 2,151.6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 147.3 сая төгрөгийн үйл ажиллагааны бус зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

3.5.3 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Тайшир сумын ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын “Сумын 2021 оны төсөв тодотгон батлах тухай” 02 дугаар тогтоолд зааснаар Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 34.6 сая төгрөгийн татварын, 2.0 сая төгрөгийн татварын бус нийт 36.6 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 43.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 118 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг төлөвлөснөөс хөрөнгийн орлогыг 0.8 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 0.2 сая төгрөгөөр тасарсан байна. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.

Орлогын гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад өндөр дүнгээр нэмэгдсэн татварын болон татварын бус орлогын төрөл байхгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв


Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайшир сумын төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төслийг нэгтгэн гараагүй байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 2 дугаар тогтоолоор 1,948.6 сая төгрөгийг сумын төсвөөс 2021 оны төсвийн жилд зарцуулахаар баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл



Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 1,948.6 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,713.8 сая төгрөгийг урсгал зардалд, 147.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлд 86.9 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 928.4 сая төгрөгийг улсын төсвөөс буюу тусгай зориулалтын шилжүүлгээс, 890.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 113.9 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 16.1 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн санхүүжилтийг тус тус бүрэн авсан. ЭМТ нь ЭМДСангаас 11.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус дутуу авсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдлээс 14.6 сая төгрөг, СХС-гийн 8.8 сая төгрөгийг олгоогүй, зарцуулалт гараагүй байна.

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 118.3 сая төгрөг бүрдүүлж 37.7 сая төгрөгөөр давсан нь Сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө болон ЗДТГ-ын өөрийн орлогын төлөвлөгөө тус тус давж биелсэнтэй холбоотой.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,851.6 сая төгрөг буюу 95 хувьтай байгаа нь зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд

- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 105.0 сая төгрөг
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 5.8 сая төгрөг
- Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого 48.5 сая төгрөг нийт 159.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс нэмэгдэл урамшилд 7.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 1.5 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 0.1 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 3.9 сая төгрөг, норматив зардалд 35.1 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 4.0 сая төгрөг, томилолтын зардалд 1.1 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 2.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 74.7 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 26.6 сая төгрөг нийт 156.2 сая төгрөгийг зарцуулж, ЭМТ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 3.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.


Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.



3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

ТТЗ : Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 36 мэдээллийг “Тайшир сумын Засаг дарга” цэсэнд ил тод бүрэн байршуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Тайшир сумын Соёлын төв тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 26 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна. 5 саяас дээш дүнтэй орлогын 12 гүйлгээг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Тайшир сумын ИТХ тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 20 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 9.0 сая төгрөгийн 3 заалт албан шаардлага хүргүүлсэн бөгөөд шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангасан байна.

Харьяа нэгж байгууллагын тухайд:

Сум хөгжүүлэх сангийн өмнөх шийдвэрийн үлдэгдэл 1.7 сая төгрөгийн үлдэгдэлд мэдэгдэл хүргүүлсэн байна.

Хэрэгжээгүй шийдвэрийн тухайд байгууллагын удирдлагад биелэлт ирүүлэх албан бичиг хүргүүлсэн төдийгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулсан байна. Цаашид санхүүгийн ажилтны хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байж өмнөх аудитын шийдвэрийг хангаж ажиллах нь зүйтэй байна.


3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар орон нутгийн орлого, татварын тодорхойлолт, өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Дараа жилийн түүвэрт хамрагдах нэгж байгууллагын аудитаар цалин, бараа материалын тайлангийн зарцуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг хэрхэн хэрэгжүүлж ажилласныг шалгах нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгайн сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллага, 1 санд дүгнэлт гаргаж, 2 байгууллага, 2 сангийн ажил гүйлгээг түүвэрт хамруулсан.



Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4, “Хязгаарлалттай” 1 дүгнэлт өгсөн байна.

Дүгнэлт гарсан нэгж байгууллагын аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг аудитын дүгнэлт гарсан нэгж байгууллагуудад 194.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 87.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 4.9 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 102.4 сая төгрөгийн 16 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 12.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн залруулга:

Тайшир сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Түүвэрт хамрагдсан байгууллагын тайланд хийгдсэн залруулга:

Соёлын төв нь тайлант онд 0.2 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн.

ИТХурал нь тайлант онд 0.2 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг нөхөж шивүүлсэн.

4.2 Төвлөрүүлэн захирагчийн Төлбөрийн акт

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

Түүвэрт хамрагдсан байгууллага

Тайшир сумын Соёлын төв:

Цалингийн урьдчилгаа 0.2 сая төгрөгийн ажилтнаас суутгаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Төвлөрүүлэн захирагчийн Албан шаардлага

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хувьд

Хөрөнгийн орлогын төлөвлөгөөг 0.8 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 0.2 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлогыг 0.5 сая төгрөгөөр тус тус тасалсан нь Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 02-ны

өдрийн 02 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн өөрийн орлогын төлөвлөгөөг 7.8 сая төгрөгөөр тасарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.


Түүвэрт хамрагдсан байгууллага

Тайшир сумын Соёлын төв:

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүй, төсөвт 10%-с доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй байгаа нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах," гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 1.9 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 242.2 сая төгрөгийн 19 мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого мөнгөн гүйлгээ нийт 82.3 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5-т "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.



Тайшир сумын ИТХ:

Татварын тодорхойлолтоор 1.1 сая төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,"; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Төвлөрүүлэн захирагчийн Зөвлөмж

Түүвэрт хамрагдсан байгууллага

Аудитаар Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Тайшир сумын Соёлын төв:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугар зүйлийн 16.5.7-д "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Тайшир сумын Эрүүл мэндийн төв:

2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан боловч дүгнээгүй байна.
- 2.2. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 16 дугар зүйлийн 16.5.7-д "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
ТТЗ											
Тайшир сумын ТТЗ	3	9.3	0	0	0	0	0	2	9.3	1	0
Түүвэрт хамрагдсан байгууллага											
Соёлын төв	3	2.1	0	0	1	0.2	2	1.9	0	0	0
ИТХ	1	1.1	0	0	0	0	1	1.1	0	0	0
Дүн	4	3.2	0	0	1	0.2	3	3.0	0	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
ТТЗ	0	0	0	0	0	0	0	0	0	1	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Соёлын төв	2	0.2	1	0.2	0	0	1	0	0	0	0
ИТХ	1	0.2	1	0.2	0	0	0	0	0	0	0
Дүн	3	0.4	2	0.4	0	0	1	0	0	0	0
Нийт дүн	10	12.9	2	0.4	1	0.2	5	12.3	1	0	0

